

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-21

1.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох;	4-21
--	------

2.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хил, зааг дотор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг “Онтрэ” компанийн хувьцааны төрийн эзэмших хувь хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийх, холбогдох асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх/-ны 10 дугаар сарын 21-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 29 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ө.Шижир;

Чөлөөтэй: Б.Жаргалан, Д.Пүрэвдаваа.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан хуралдаанд оролцов.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Б.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаясгалан, С.Зулпхар нар үг хэлэв.

Хянан шалгах түр хорооны гишүүд Оюу толгой ХХК-ийн танилцуулга, мэдээллийг сонсох буюу хэлэлцэх асуудлын дарааллын 3 дахь асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хасах горимын санал гаргав.

О.Батнайрамдал: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 1

Бүгд: 7

85.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Оюу толгой ХХК-ийн танилцуулга, мэдээллийг сонсох асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлын дарааллаас хасав.

Хэлэлцэх асуудлын дарааллын 1, 2 дахь асуудлуудыг хамтад нь хэлэлцэхээр ТОГТОВ.

Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох;

Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хил, зааг дотор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг “Онтрэ” компанийн хувьцааны төрийн эзэмших хувь хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай

хэлэлцээр хийх, холбогдох асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Ганхүү, мөн компанийн Геологи, уул уурхайн хэлтсийн менежер Л.Өнөрбаатар, Санхүү, шинжилгээний хэлтсийн менежер Б.Баяр-Өлзий, Монгол талын ТУЗ-ийн гишүүн Э.Мэндтүвшин, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Чанар, бүтээмж хариуцсан менежер Д.Ядамжав, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Б.Цэлмэгтуяа, Төслийн үнэлгээний хэлтсийн менежер Ү.Чулуунбаатар нар оролцов

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн, Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг ажлын хэсгийн ахлагч, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Ганхүү нар хийв.

Мэдээллүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Э.Болормаа, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67, 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллүүдийг сонслоо.

Хянан шалгах түр хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 00 минут үргэлжилж, 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 29 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХЯНАН
ШАЛГАХ ТҮР ХОРОО /ОЮУ ТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН АШИГЛАЛТАД МОНГОЛ
УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ
ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ/
НЫ 10 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

О.Батнайрамдал: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Оюу толгой бүлэг ордын ашиглалтын асуудлаарх хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2025 оны 10 сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн ирцийг та бүхэнд танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар, Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзориг, Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа, Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал гээд 54.5 хувьтай ирц танилцуулж байна.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох.

Хоёрдугаарт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хил, зааг дотор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг “Онтрэ” компанийн хувьцааны төрийн эзэмших хувь хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийх, холбогдох асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсоно.

Гуравдугаарт, Оюу толгой компанийн ТУЗ-ийн дарга гишүүд гүйцэтгэх, удирдлагын багийн танилцуулах мэдээлэл сонсох гэсэн 3 асуудлын товыг та бүхэнд танилцуулж байна.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу? Тэрийг нөгөө юун дээрээ тийм асуудал дээрээ орохоор. Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Энэ 3 дахь асуудал дээр чинь нөгөө нэг Оюу толгой компани ирнэ гэж ойлгосон зөв үү? Өнөөдөр бид нар дээр энд мэйл ирчихсэн байна л даа. Энэ удаад бидний зүгээс товлөгдсон хуралдааны мэдээллийг хүндэтгэн хүлээн авч байгаа боловч оролцохоос татгалзаж байна аа гэж байгаа юм. Тэгээд манай шийдвэр одоогийн нөхцөл байдалтай холбоотой бөгөөд улс төрийн хурц уур амьсгал Оюу толгойн оффист үргэлжилсээр буй эсэргүүцлийн суулт гээд ингээд ингээд цаашаа явж байгаа юм. Энэ тэгэхээр оролцохгүй юм байна. Албан бусаар бид нар энэ манай Түр хорооны ажлын хэсгийн гишүүд маань Оюу толгой компани

дээр очиж ажиллая даа, очиж мэдээллээ авъя албан бусаар. Одоо энд ирэхээр их аюултай байгаад байх шиг байна. Тэгэхээр бид өөрсдөө л очъё. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхэд чинь энэ албан байгууллагадаа очиж мэдээлэл авах эрх нь байж байгаа байх тийм ээ.

Хоёрт энэ доор нэг ийм зүйл байж байна. Яах вэ би энэ 2 бодит үр дүнтэйгээр 2025 оны 10 дугаар сарын сүүлээр ярилцахад бэлэн байна аа гэж байгаа. Бодит үр дүн гарах юм байна аа гэдгийг энэ дээр илэрхийлчихсэн байна.

10 дугаар сарын сүүл гэдэг чинь ирэх 7 хоног орчхож байгаа. Тэгэхээр ажлын хэсгийн дарга, түр хороо ахлагч та энэ 2 юуг хагалаад ирэх 7 хоногт яг ирэх үү, ирэхгүй юу, аюултай гээд ирэхгүй байж магадгүй. Ирэхгүй гэж байгаа бол албан бусаар бид нар очиж Оюу толгой компанийн байранд нь очиж тэр үүсээд байгаа нөхцөл байдалтай нь ч танилцъя, мэдээллээ ч авъя.

Дараагийн асуудал тэр ер нь яг энэ уул уурхай энэ газар дээр нь очиж энэ Түр хороо нэг ажиллах нь зөв байх. Тэр Онтрэ гээд яг тэр компанийн эзэмшиж байгаа орд дээр нөхцөл байдал дээр нь очиж нэг танилцаад тэр гүний уурхайтай нь очиж нэг танилцаж үйл ажиллагаагаа нэг харах нь зөв байх гэж бодож байна.

Гуравт тэр ирсэн материалууд чинь бүгд нууц гэчихсэн байх юм. Тэгээд энийг чинь нууц гээд дараад ирүүлчихсэн материалтай чинь бид нар ер нь яаж танилцах вэ? Нээлттэй хурлаар бид нар танилцах ямар ч боломжгүй болчихож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр энэ Оюу толгой компани ер нь яг ямар байр суурьтай, ер нь энэ нууцлалд авсан журам юм нь та нар татаж авч үзсэн үү барьсан уу? Энэ яг нууцлах ёстой материал мөн юм уу, биш юм уу? Мөнхбаясгалан гишүүн тагнуул холбогдох хууль сахиулах байгууллагаас нь мэдээлэл авахаар ямар ч нууцлах үндэслэл алга байна аа гээд ингээд хариу ирүүлчхээд байдаг.

Гэтэл ААН нь нууцалчхаад явуулаад байдаг. Тэгэхээр энэ чинь сүүлдээ бид нар өөрсдөө нууц задалсан хэрэгт, байгууллагын нууц задалсан хэрэгт орчих магадлалтай учраас энэ дээр яг нэг зохистой шийдвэр гаргах ийм зайлшгүй шаардлага байна гэж үзэж байна.

О.Батнайрамдал: Баярбаатар гишүүний саналыг сонслоо. Бүгдээрээ хэлэлцэх асуудлын талаар гэж байгаа шүү дээ. Тэгэхээр 3 дахь асуудал нөгөө Оюу толгойн асуудал ирэхээр бид нар энэ дээр бүгдээрээ 3 дахь асуудал яриад эхлэхээр санал асуултаа асуугаад үгээ хэлье тэгэх үү? Одоо бол нөгөө хэлэлцэх асуудлын талаар та Бат-Эрдэнэ гишүүн. Гурав дахь асуудлаас асууя.

Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг.

Б.Бат-Эрдэнэ: Баярбаатар дарга санал хэлээд л байна л даа. Би болохоор ингэж энэ албан ёсны ирсэн мэйл гэж би ойлгож байгаа. Тэгээд энэ дээр болохоороо ингэж байгаа байхгүй юу. Манай зүгээс цаашид Хянан шалгах түр хороотой оролцогчдыг хүндэтгэсэн аюулгүй орчныг бүрдүүлсэн нөхцөлд яриа хэлэлцээг өрнүүлэхтэй нээлттэй байх болно оо гээд байгаа юм. Тэгээд бид нар чинь Оюу толгойн Хянан шалгах аороо бол тэд нартай хэлэлцээр хийх гээгүй гэж би ойлгож байгаа. Энэ Оюу толгой компани чинь бид нарыг хэлэлцээр хийнэ гэж ойлгочоод байгаа юм биш үү? Тэгэхээр энэ бичсэн мэйл дээр нь харин ингэж бичээд байна шүү дээ. Яриа хэлэлцээг өрнүүлэхтэй нээлттэй байгуулна гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид нар бол Оюу толгойн Түр хянан шалгах хороо бол Оюу толгой компанитай хэлэлцээр 1 дүгээрт хийх гэж байгаа гэж би ойлгохгүй байгаа.

Хоёрдугаарт аюулгүй орчныг бүрдүүлсэн нөхцөлд гээд Баярбаатар даргын саяын санал бол очъё гэж байх шиг байна.

Хоёрдугаарт ахиад нэг ярьсан санаа нь бол байгууллагын нууцын тамгатай асуудал яригдаад байна. Тэгвэл эндээ дуудаад аюулгүй орчныг нь хангасан байдлаар аюулгүй орчныг нь бүрдүүлж өгөөд хаалттай хуралдчихвал болохгүй юм уу гэдэг санал байна надад эсрэгээрээ. Тэгээд яах вэ зүгээр манай Оюу толгой компани энэ дээр бичээд байгаа нь бол бид ажилтнууд болон удирдлагуудынхаа аюулгүй байдал нэр төрийг нэн тэргүүнд тавьж, нэн тэргүүнд тавьж, бодит ахиц дэвшилд талуудын хамтын ажиллагаа харилцан ойлголцлын үр дүнд хүрнэ гэж үзэж байна гээд байгаа байхгүй юу. Тэгээд бид нар Монгол Улсын эрх ашгийг нэг номерт тавьж байгаа шүү дээ. Оюу толгой компани бол удирдлагуудынхаа аюулгүй байдал нэр төрийг нэн тэргүүнд тавиад байгаа юм. Тэгээд энэ чинь 2 өөр байхгүй юу.

Тэгэхээр бид нар улсынхаа эрх ашгийг нэн тэргүүнд тавьж байгаа тангараг өргөсөн Улсын Их Хурлын гишүүдийн хувьд. Хэрвээ нөгөө үнэхээр материалууд нь нууцын тамгатай байгаад байгаа бол хаалттай горимоор хэлэлцэхээр хийгээд энэ ойлголтын зөрүү буюу бид нар хэлэлцээр хийх гээгүй ээ. Бид нар бол та бүхнээс асуух ёстой, тодруулах ёстой зайлшгүй шаардлагатай зүйлсийг л тодруулах гээд байна. Оюу толгой компани бол та бүхэнд аль хэзээний бид нар хэдэн мянган хуудастай материал хүргүүлчихсэн. Тэрэн дотроосоо өөрсдөө үз гэдэг зарчим бариад байна шүү дээ. Бид нар тэрэн дотроос нь асуух асуултуудаа асуумаар байгаа байхгүй юу. Тодруулах шаардлагатай гэсэн үг.

Тэгэхээр дараагийн хурлыг энэ 7 хоногийнхоо даргын зөвлөлийн хурал дээр яриад, дахиж ирэх 7 хоногт тавиад хаалттай горимоор нөгөө хаашдаа нууцын тамгатай бол тэгээд тэр нууцлалынх нь шинж чанарыг хадгалаад хаалттай горим дээр явж байгаа юм чинь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр илүү дутуу асуудал явахгүй. Ингээд Төрийн ордонд бид нар хамгийн аюулгүй орчинд байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд энэ систем дээр нь энэ хүмүүсийг дахиад дуудаад албан бичиг явуулахдаа бид нар хэлэлцээр хийх гээгүй ээ та бүхэн буруу ойлгоод байна аа гэдгийг нь хэлээд явуулчихвал ямар вэ?

Тэгээд 3 дугаар асуудал хаашдаа өөрсдөө ирээгүй учраас хэлэлцэх асуудлаас хасаж өгнө үү гэдэг ийм саналтай байна.

О.Батнайрамдал: Бат-Эрдэнэ гишүүн санал гаргалаа. Мөнхбаясгалан гишүүний микрофоныг өгье.

Та орсон уу хуруугаа хийж орсон уу эхлээд. Мөнхбаясгалан гишүүний микрофоныг. Ирцэд ороогүй байна уу?

Л.Мөнхбаясгалан: Ирц байхгүй биз дээ. Би энэ ажлын хэсэгт байхгүй л дээ, Хянан шалгах түр хороонд байхгүй. Тэгэхдээ ТЕГ-аас авсан тайлбар бол 2 удаа Засгийн газар руу нууцаас гаргах ёстой, нууцад авах ямар ч үндэслэл байхгүй гэсэн мэдээлэл өгсөн байдаг юм байна лээ. Тэгээд Төсвийн байнгын хорооноос энийг нууцаас гаргаач ээ энэ ямар ч юу яахгүй гэхэд л зөвхөн аудит ч гэсэн энэ бол ерөөсөө Оюу толгойн хүсэлтээр л авсан бид нар байгууллагын нууцаар авсан гээд

л тэгээд байдаг юм байна лээ. Тэгээд би зүгээр ингэж л бодож байна. Энэ доод талын өгүүлбэрийг харахад аюулгүй орчныг бүрдүүлсэн нөхцөлд гэж байна шүү дээ.

Тэгэхээр аюулгүй орчныг бүрдүүлнэ гэж яадаг юм. Одоо нөгөө хуучин ЦЕГ-ын тусгай тасгаас хамгаалалт авч өгдөг байсан. Энэнд тайлбар гаргуулаад тэгээд тэр цэрэг цагдаагийнх нь хамгаалалтаа Монгол Улсын Төрийн ордонд орж ирээд Монгол Улсын Их Хурал дээр байгуулагдсан Хянан шалгах түр хороонд орж ирэхийг нь харъя л даа бүгдээрээ. Тэр хуяглан хамгаалалтыг нь хийгээд өгөөч Батнайрамдал дарга аа. Тэгээд бас ажиллаж болно шүү дээ. Очно гэж байхгүй шүү дээ. Энэ нөгөө газрын тосны үйлдвэрийн ажлын хэсэг дээр бас энэ явдал тохиолдож байсан байхгүй юу. Бас л нууцын ямар ч юу хангаагүй байхад нууцад авчихсан байдаг. Тэр нь тэгээд нуугаад байх ч юм байхгүй. Нэг тийм л юм байна лээ.

Тэгэхээр энэ Монголын төрөөс төрийн толгой дээр гишгэчихсэн ийм том компанитай бол хатуухан ярьсан нь зөв байх аа. Миний цуглуулсан материалаар бол сонин сонин юм гарч ирж байгаа. Би тэгээд танай Хянан шалгах түр хороонд оръё гэхээр асуудалтай л байгаад байгаа юм.

О.Батнайрамдал: Бүгдээрээ дэгээрээ явах ёстой. Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр гишүүд байна уу? Хэлэлцэхээр байгаа шүү дээ тиймээ. Гэхдээ сая хэлэлцэхийг хасуулъя гэж сая дүгнэлт гарч байна тийм үү. Тэгэхээр бид нар санал хураалгах ёстой шүү дээ тэ? Тэгэхээр санал хураалт өгөхөөс өмнө Хянан шалгах түр хорооны даргын хувьд нэг байр суурь илэрхийлье гэж бодлоо. Аюулгүй орчныг бүрдүүлэх гэдэгт.

Тэгье Зулпхар гишүүний микрофоныг өгье.

С.Зулпхар: Түр хороон дарга, гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Бидний хувьд бол яах вэ хэлэлцэх 3 асуудал байгаагаас 3 дахь асуудал маань үндсэндээ хэлэлцэгдэхээргүй ийм нөхцөл байдалтай байгаа юм байна. Учир юу гэхээр зэрэг Оюу толгой компаниас бидэнд албан мэйл ирсэн байна л даа. Албан захиа биш албан мэйл ирсэн байна. Тэгээд сая гишүүд их тодорхой байр суурь илэрхийлж байна л даа. Тэгээд тэр байр суурьтай уялдуулаад би 4 зүйл хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт энэ албан захиан дээр яах вэ Монгол орчуулга дээр нь алдаа байж магадгүй юм шиг байгаа юм. Нөгөө талд ингэсэн байна л даа. Түр хороотой, оролцогчдыг хүндэтгэсэн аюулгүй орчныг бүрдүүлсэн нөхцөлд яриа хэлэлцээ хийнэ гэчихсэн байгаа юм. Энэ яриа хэлэлцээ гэдэг нь аягүй англи үгийг Монгол руу хөрвүүлэхдээ буруу хөрвүүлчихсэн юм болов уу? Тэрнээс угаасаа их ойлгомжтой юм яриад байна шүү дээ. Бид ямар нэгэн яриа хэлэлцээр хийх биш Түр хороо бол өөрөө дуудаж ирүүлээд мэдээллээ авах гэж байгаа ийм л үйл явц явж байгаа учраас 1 дүгээрт энийг нэг тодруулъя.

Хоёрдугаарт бол бид бол ямар нэгэн байдлаар хуулийн хүрээнд бол ямар ч байгууллагыг ямар ч хуулийн этгээдийг гэе л дээ. Дуудаж ирүүлж бид мэдээлэл авах л ийм л эрхтэй шүү дээ. Тэгэхээр бид энэ эрхээ эдэлж байна гэдгээ нөгөө талд их тодорхой энийг дахин сануулмаар байна, албан ёсоор сануулмаар байна. Өнгөрсөн удаад бид ингээд яриад өнгөрсөн. Одоо бичиг энэ удаа очоогүй байх. Бид бичиг хүргүүлэх ёстой болж байна.

Хоёрдугаарт тэр албан бичиг дээр бол та бүхэн хүрэлцэн ирэх үүрэгтэй шүү гэдэг хууль сануулмаар байна. Тэр хуулийг жишээ нь сануулахгүй болохоор чинь зэрэг нөгөө нөхдүүд маань болгоомжилсон янз янзын юм байгаа байх.

Дөрөвдүгээр зүйл бол энэ сая гишүүд маань хэлж байна. Үнэхээрийн мэдээж хэрэг аюулгүй нөхцөл байдал үүссэн байхгүй байна, олон нийтэд харагдмааргүй байна. Хувь хүний хувьд би энэ асуудлыг жичид нь яримаар байна гэж байгаа бол энэ тэдний эрхийн асуудал байж болох юм. Энэ нөхцөлд нь сая Бат-Эрдэнэ гишүүний хэлсэнчлэн хаалттай горимоороо бид нар хуралдаж байна шүү дээ. Тэгээд тэр компанийн тодорхой, албан хаагчдын, иргэний гадна дотнын жишээ нь иргэдийн тэр улсуудын эрхийг хүний эрхийнх нь талаас нь хангах асуудалд л бид анхаарах ёстой юм байна аа гэж ойлгож байна.

Төгсгөлд нь нэг л зүйл байгаа. Улсын Их Хурал гэдэг чинь хуульд л хяналт тавих үүрэгтэй ийм субъект шүү дээ. Би энэ эрхээ л эдэлж байгаа. Өөр ямар нэгэн юм хүсээгүй шүү. Яг энэнтэй уялдсан байдлаар нийт Монголчуудын 3.5 сая Монголчуудын эрх ашгийн асуудал дээр л бид ярьж байгаа. Өөр юм энэ дээр хувийн сонирхол, хувийн асуудал ярих орчин биш гэдгийг дахин нотолж хэлэх ёстой гэж бодож байна аа.

Тийм учраас 3 дахь асуудлыг ер нь санал гаргаад манай гишүүдийн хэлсэнчлэн хэлэлцэх асуудлын жагсаалтаас хасахаас өөр аргагүй юм байна л гэж ойлгож байна.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүн 3 дахь асуудлаа хэлэлцэх асуудлаас хасъя гэж байна. Тэгэхээр 2 асуудал, 2 санал хэллээ гэж ойлголоо.

Нэгдүгээрт бол Оюу толгойн хэрвээ Аюулгүй орчин парламентын ордонд бүрдэхгүй байна ирж чадахгүй гэж байгаа бол бүгдээрээ очъё гэдэг саналыг гаргаж байна.

Хоёрдугаарт Бат-Эрдэнэ гишүүн хаалттай тиймээ, парламентын ордондоо хаалттай явуулъя гэсэн 2 санал гарч байна гэж ойлгож байна.

Хянан шалгах түр хорооны даргын хувьд би нэг байр сууриа илэрхийлье. Бид нар Хянан шалгах түр хороо ингээд 3 сар орчим байгуулснаасаа хойш ингээд үйл ажиллагаагаа явуулж байна. Бид нарын хамгийн нэг том гарч ирж байгаа даваа яг энэ нууц гэдэг тамга дардаг, эсвэл хаалттай гэсэн ийм асуудал л яваад байна л даа. Тэр 30 гаруй мянган хуудас баримт бичиг явуулсан. Бүгдээрээ нууцын тамга дарчихсан байгууллагын нууц гээд тамга дарчихсан учраас бид нар тэр байгууллагын зөвшөөрөлгүйгээр олон нийтэд нээлттэй болгох ингээд эрхгүй болчихож байгаа юм.

Тэгэхээр буцаад бид нар нээлттэй сонсголыг олон нийтэд мэдэх эрхээр нь хангаж явуулах ёстой. Тэгэхээр энэ эрх маань ингээд хангагдахгүй нэг ийм зөрчилтэй тулгарч байгаа юм.

Хоёрдугаарт үнэхээр парламентын ордонд аюулгүй орчин бүрдэхгүй бол хаана хуралдах нь хамаагүй шүү дээ. Албан бусаар Оюу толгойн байран дээр бид нар өөрсдөө очоод, Улсын Их Хурлын гишүүд Хянан шалгах түр хороо очих бүрэн эрхтэй. Мэдээллээ л авъя гэж байгаа юм. Бид нар энэ дээр ямар нэгэн яриа

хэлэлцээр хийхгүй гэдгээ би дахин илэрхийлье. Албан ёсоор протоколд үлдээе. Бид нар хэлэлцээр хийдэг субъект биш ээ.

Их Хурлын тов дээр орохдоо бол та бүхэн уншиж байна. Оюу толгой компанийн удирдлагын багийн танилцуулга, мэдээлэл, сонсгол гэж байгаа юм. Нэг ёсондоо Оюу толгой компани өөрсдөө гүйцэтгэх удирдлагын хүрээнд ирээд өөрсдийнхөө байр суурийг илэрхийлээд явж байгаа процессоо л бид нарт танилцуулгаар хийх ийм л мэдээлэл өгөх л ийм л асуултыг бид нар асууж байгаа юм.

Тэгэхээр хувьдаа би хаалттай явуулахыг дэмжихгүй байна. Яагаад гэх юм бол хаалттай явуулах юм бол бид нар эндээс яригдсан зүйлийг гараад иргэддээ ярих эрхгүй болно гэсэн үг. Тэгэхээр бид нар өөрсдөө хаалттай явуулахыг эсвэл тэр нууц баримтыг зөвшөөрөх тусмаа бид нар дараа нь яаж нээлттэй сонсголыг явуулах вэ? Тэгэхээр энэ чинь энэ асуудлаа шийдэх гэж байтал нөгөөдүүл парламентын ордонд аюулгүй орчин бүрдэхгүй байна гэдэг агуулгаар бид нар хурлаа хаалттай явуулна гэвэл өөрсдөө тэрийгээ дараа нь бид нар ард түмэндээ тайлагнах эрхгүй болно шүү дээ. Тэгэхээр зарчмын хувьд энийг дэмжихгүй гэж бодож байна. Дэмжих нь миний хувьд дэмжих боломжгүй юм байна. Харин тэр Мөнхбаясгалан гишүүн хэллээ. Аюулгүй орчныг бүрдүүлэхэд албан тоот Оюу толгой компани руу явуулах гэж байгаа. Гишүүдээсээ тэр драфт дээр саналаа өгөөрэй гэж хүсье. Тэрэн дээр харин бид нар яаж аюулгүй орчныг бүрдүүлэх дээр жишээлбэл анхааръя тиймээ яг яаж бүрдүүлэх ёстой юм? Тэгээд парламент дуудаад ялангуяа Үндсэн хуулиар олгогдсон ард түмний өмчийг ард түмэнд нь тайлагнах эрхийг танилцахыг хүсэж байгаа ард түмний төлөөлөлд нь тайлагнах үүрэгтэй тиймээ? Тэгэхээр энэ үүргээ бол ямар ч компани ямар ч ААН бүгдээрээ л биелүүлэх ёстой.

Тийм учраас зарчмын хувьд бол бүх хурлаа ямар ч байсан томилгооноос бусад бүх хурлаа бид нар нээлттэй явуулж байгаа. Зарчмаа хянан шалгаж түр хороо анхны хурлаараа бид тэр гишүүд бүгд дуу нэгтэйгээр зөвшөөрч байсан. Тэгэхээр Оюу толгойд аюулгүй орчин бүрдэхгүй байна гэдэг утгаар хурлаа хаалттай явуулна гэдэг нь зарчмын хувьд буруу л гэж бодож байна. Ийм саналтай байна.

Тэгэхээр ийм 2 санал гарсан. Тэгээд бүгдээрээ тэгвэл санал хураалт явуулчих уу. Санал хураалт явуулж шийдчих үү? Бат-Эрдэнэ гишүүний микрофон өгье. Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Яах вэ нээлттэй, хаалттайгийн хувьд нэг л концепц ярьсан шүү дээ. Асуудлууд дээр чинь байгууллагын нууцын тамга дарчхаад байгаа учраас хаалттай явуулбал яах юм бэ л гэсэн байхгүй юу. Бид нар очиж болно тэгээд байгууллагын нууцдаа дарчихсан тамгатай дээр бид нар хэвлэл авч очих юм уу? Яаж нээлттэй байх юм? Оюу толгой компани дээр тухайлах юм бол. Тэгээд л хаалттай байхгүй юу. Ялгаа байхгүй. Тэнд бид нар ямарваа нэг хэвлэл мэдээлэл байхгүй, ямарваа нэг мэдээлэлтэй танилцахдаа байгууллагын нууцтай холбоотой асуудал, тамга тэмдэгтэй бичиг цаастай холбоотой асуудал тодорхой мэдээллүүдийг бид нар сонсоно сонсоно. Тэгээд яг зарчмын хувьд наадах чинь адилхан байхгүй юу.

Тэгэхээр бид нар олон нийтэд нээлттэй байх ёстой. Гэхдээ нээлттэй байхдаа зарим тохиолдолд хаашдаа нууцын тамгатай байгаа тохиолдолд хаалттай зарим тохиолдолд уралдахаас өөр арга байхгүй. Оюу толгойн Хянан шалгах түр хорооны

сонсгол бол нээлттэй явагдана, нээлттэй явагдана. Тэгэхээр тэр үеэрх процессоо бид нар яаж шийдвэрлэх вэ л гэдгээ харахгүй бол нээлттэй хаалттайн хувьд бол тэр нууцын тамгатай бичгээс чинь л холбоотой болчхоод байна шүү дээ. Тэрийг л хэлээд байгаа юм. Тэрнээс биш ордонд орж ирж байгаа хүмүүс юу ярьж байгаа эсвэл зураг видеог нь явуулах явуулахгүй асуудал яриагүй шүү дээ тийм.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүний микрофон.

С.Зулпхар: Яах вэ би нөгөө Оюу толгойгоос ирсэн бичгийг уншсаны үндсэн дээр яах вэ бид чинь манай Улсын Их Хурал чинь хүний эрхийн мэдрэмжтэй үйл ажиллагаа явуулна гээд бид ингээд тунхаглачихсан шүү дээ. Манай стратеги тийм байхгүй юу. Тэгээд Оюу толгойн тэр албан хаагч нар ажилтнууд бид ингээд олон нийтийн өмнө гараад өөрсдийгөө тэр чинь Монгол Улсууд л байгаа шүү дээ. Монгол хүмүүс байгаа, гаднын улсууд ч байгаа байх. Тэгээд олон нийтэд харагдахгүйгээр бид энэ асуудлыг яримаар байна гэж байгаа бол бид энэ хүний эрх талаас нь энийг харгалзах ёстой юу гэж байгаа юм? Харин энд хэлэлцэгдсэн зүйлийг гараад хэвлэлийнхэнд ярих нь бол нээлттэй. Тэр улсууд царай зүсээ харгуулахгүйгээр жишээ нь мэдээлэл өгвөл өгнө биз. Тэртээ тэргүй сонсгол дээр угаасаа ирж таараа нээлттэй явж таараа. Хэрвээ тийм бол бидэнд нэг тийм хувилбар байна аа л гэж байгаа юм. Энийг би зүгээр ярьж байгаад шийднэ ээ л гэж байгаа юм. Энийг байнга бодож байх ёстой шүү. Ер нь хувь хүний өөрийнх нь эрх өөрт нь одоо жишээ нь ямар нэгэн одоо нэр төр, нандин чанарыг нь хадгалсан байдал алдагдах юм бол энэнээс байнга эмзэглэдэг. Энэний тэр хүний оронд би байсан ч гэсэн тодорхой нөхцөлтэй бол тэгнэ шүү дээ. Тэрийгээ илэрхийлсэн үү үгүй юу гэдгийг тодорхой хэлье.

Тэрнээс давсан илэрхийлэл байх юм бол сая Бат-Эрдэнэ гишүүний хэлсэн шиг бид угаасаа нээлттэй байх зарчмаа хадгалж л байгаа тэрүүгээр явж болох байх аа гэж бодож байна.

О.Батнайрамдал: Өөр тайлбар хэлэх гишүүд байна уу? Тэгэхээр юу юм байна. 2 санал гарвал Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиараа гаргасан эхний санал дээр санал хураалт явуулах юм байна.

Дэмжигдвэл тэрүүгээрээ явна, дэмжигдэхгүй дараагийн санал руу ордог. Тэгэхээр сая түрүүн хэлсэн Баярбаатар гишүүний саналын томьёоллоор тэгвэл бүгдээрээ санал хураагаад шийдэх ёстой юм байна. Тэгвэл одоо хэрвээ ийм эрхгүй тохиолдолд энэ асуудлаасаа Оюу толгой компанийн танилцуулгыг хасаад дараагийн хурал дээр Оюу толгой компанийн байран дээр бүгдээрээ хамтдаа очиж албан бусаар уулзах ийм саналын томьёолол тэгвэл гарах юм байна тиймээ. Албан энэ ирц тэнд албан бусаар юм уу, албанаар хуралдаж болох уу? Тиймээ тийм зүгээр л хуралдана. Тэгээд танилцах энэ чинь дандаа танилцуулга л явж байгаа шүү дээ тиймээ. Газар дээр нь очиж тэгэхээр танилцуулах гэсэн томьёоллоор тэгээд санал хураалт явъя. Зүгээр ер нь бид нарын гаргаж байгаа шийдвэр шүү дээ.

Тэгвэл бид нар чинь хэлэлцэх асуудлын талаар явж байгаа шүү дээ. Тэгэхээр саналын томьёолол тэгээд сая бүгдээрээ хэлэлцэх асуудлаас хасъя гэсэн шүү дээ тиймээ? Тэгээд хэлэлцэх асуудлаас өнөөдрийн хэлэлцэх асуудлаас Оюу толгойн танилцуулгыг хасъя гэсэн саналын томьёоллоор тэгвэл санал хураалт явуулъя.

Санал хураалтдаа бэлдэнэ үү.

Гишүүд санал хураалт.

Нийт гишүүдийн 85.7 хувиар санал дэмжигдлээ.

Өнөөдөр Оюу толгой компанийн танилцуулга мэдээлэл сонсох ийнхүү өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдлаа.

Дараагийн асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал дээр өөр санал байхгүй бол дараагийн асуудалдаа оръё.

Хянан шалгах түр хорооны өнөөдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан 67, 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүд байгаа. Дамдинням сайд хамтад нь нэгтгэж явах гэж байна уу тиймээ.

Тэгвэл 67, 73 дугаар 2, 3-д байгаа ажлын хэсгүүд хамтдаа хэлэлцээрт орж байгаа нэг ажлын хэсэг гэдэг агуулгаар хамтад нь явуулъя. Тэгээд ажлын хэсгийн гишүүдийг оруулъя.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням. Нэмэлтээр Эрдэнэс Монгол компаниас Чанар, бүтээмж хариуцсан менежер Ядамжав, төслийн үнэлгээ хариуцсан менежер Чулуунбаатар, Сангийн сайд Жавхлан. Жавхлан сайд ирсэн юм уу? Жавхлан сайд үйлдвэрчнийхэнтэй уулзалттай байна. Гэхдээ Дамдинням сайд хоёуланг нь ахалж байгаа биз дээ. Сангийн яамны Санхүү бодлогын газрын Санхүүгийн зах зээл олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Амарбаясгалан, Эрдэнэс Оюу толгой компанийн гүйцэтгэх захирал Ганхүү, Эрдэнэс Оюу толгой компанийн Санхүү шинжилгээний хэлтсийн менежер Баяр-Өлзий, Оюу толгой компанийн Монголын талын ТУЗ-ийн гишүүн Цэрэнбат, ТУЗ-ийн гишүүн Мэндтүвшин, Ерөнхий менежер Батбаатар, Геологи, уул уурхайн хэлтсийн менежер Өнөрбаатар, ЗГХЭГ-ын дэд дарга Цолмон. Тийм бас Оюу толгой компанийн Монголын талын ТУЗ-ийн шинээр сонгогдсон гишүүн байгаа. Аж. үйлдвэр, эрдэс баялгийн яам, Намчинсүрэн дарга ирсэн байна. Ажлын хэсэг бүрэлдэхүүнээрээ хүрэлцэн ирсэн байна, танилцуулгаа хийе. Дамдинням сайдын микрофон өгье.

Г.Дамдинням: Түр хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67, 68, 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг танилцуулахад бэлэн болсон байна.

Тэгэхдээ би бол танилцуулгыг манай Эрдэнэс Оюу толгой компанийн захирал Ганхүү танилцуулга хийнэ. Гэхдээ ил шууд ингээд бас ярих асуудлуудыг бол танилцуулаад ажлын хэсэг дээр яригдсан хэлэлцээртэй холбоотой, тактикийн холбоотой, хийгдэж байгаа ажлуудтай холбоотой юмнуудаа ил ярих нь яах юм бол доо. Тэрийгээ бол хэдүүлээ бас эндээ нэг ойлголцчих ёстой байх. Манай ажлын хэсгүүд бол маш эрчимтэй ажиллаж байгаа. Жавхлан сайдаар ахлуулсан ажлын хэсэг бол зээлийн хүүгийн хэлэлцээртэй холбоотой ажлын хэсгүүд дээр хувилбаруудыг гаргаад ажил хэргийн шугамаар та бүгдтэй танилцуулга хийгээд ингээд явж байгаа. Бид бол бүх төрлийн үнэлгээг хийж үзсэн. 6 төрлийн хувилбар байгаа.

Энэ хувилбаруудаас сонгож хэлэлцээрт орно оо гэсэн ийм бэлтгэл ажлыг хангачихсан байгаа нэг.

Хоёрдугаарт Онтрэ компанийн лицензүүдтэй холбоотой асуудлыг миний бие ахалж ажиллаж байгаа. 68 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг. Онтрэ компанитай хэлэлцээрийн ажлын хэсгийн багаа ирүүл ээ гэдэг урилгыг өгөөд өнөөдөр би хариугаа хүлээгээд авчихсан байна. Энд бол би бэлтгэл ажил бүрэн хангагдсан. Онтрэ компанийн хэлэлцээр хийх хүрээнд манай ажлын хэсэг 3 дэд ажлын хэсэг гаргаад хууль эрх зүй, санхүү өмнөх хийгдэж байсан ажлуудтай холбоотой асуудлуудыг судлах чиглэлд бол ажиллаад бэлтгэл ажил хангагдсан байгаа.

Энэ хүрээнд бол энэ 2 ажлын хэсгийн хүрээнд бол бид Улсын Их Хурлын 103 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг гэж байгаа. Тэр хүрээнд энэ 3 ажлын хэсэг гурвуулаа багтаад байгаа юм. 67, 68, 73 гурав. Тэгээд менежментийн төлбөртэй холбоотой асуудлуудыг ярих тухай ажлын хэсэг д дээрээ ингээд яригдчихсан. Ингээд бэлтгэл ажил хангагдсан. Оюу толгой компаниас Рио Тинто компаниас энэ сарын сүүлээр 27, 28 хавьцаа 10 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгээ илгээж байгаа. Хүмүүсийнхээ нэрсийг өнөөдөр манайд ирүүлсэн. Манай ажлын хэсэгт ирүүлчихсэн байгаа. Онтрэ компанийн зүгээс бол өөрийн Монгол Улсын оролцоогүйгээр хийгдчихсэн байгаа 20, 80 гэж тохиролцсон тохироо гэдэг юмаараа зөвхөн 20 хувийн хүрээнд, 34 хувийн хэлэлцээрт ормоор байна аа гэсэн утгатай захидал ирүүлсэн.

Манай ажлын хэсэг болон яамны зүгээс бол энийг хүлээн зөвшөөрөхгүй. Бид бол та нартаа нэг бол хэлэлцээрийг 100 хувиар Рио Тинто болон Онтрэ компаниудыг нэгтгээд хийвэл хийнэ. Үгүй бол бид ер нь Монгол Улсыг үл хүндэтгэсэн ийм хэлэлцээрт та нарт орох шаардлага байхгүй шүү гэсэн ийм байр суурьтай байгаа. Ерөнхий сайд бид нарт чиглэл өгч тэмдэглэл гарсан.

Тэмдэглэлийн хүрээнд ямар агуулгатай тэмдэглэл гарсан бэ гэхээр бид бол нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэг эрхлэх газар дээр хэлэлцээрийнхээ удирдамжийг хэлэлцээрийнхээ бүрэлдэхүүнийг хийх ажлынхаа төлөвлөгөөг дарааллыг Хэрэг эрхлэх газар дээрээ нэгтгээд батлаад явъя аа гэдэг ийм чиглэл авчихсан байгаа. Бид энэ хүрээндээ ажлуудаа ингээд бэлтгэчихсэн. Тэгээд одоо манай Эрдэнэс Оюу толгой компанийн захирал Ганхүү дарга танилцуулга хийнэ. Ганхүү дарга бас нийтэд хэлэлцээрт орох гэж байгаа учраас та мэдээллүүдээ энэ слайд дээрээс хасаж амжсан уу? Тэрийгээ бодож танилцуулгаа хийнэ шүү дээ.

Тэгээд уг нь бол одоо нөгөө хаалттайгаар ярьчихвал уг нь чөлөөтэй сайхан ярьчихмаар байгаа. Нөгөө хэлэлцээрт орох гэж байгаа Монгол Улсын талынхаа тактикийг нийтэд дэлгээд байж болохгүй байгаа учраас хэрвээ гишүүд тэгж шийдвэл бид нар ярихад бэлэн байна. Үгүй ээ зүгээр ажлын процессынхоо хувьд бол бид нар иймэрхүү юм хийж байгаа. Ерөнхий мэдээлэл сонсох бол нээлттэй шүү. Дарга л та хэд маань л шийдээд хэлчихмээр байна.

О.Батнайрамдал: Дамдинням сайд аа бид нар урьд нь ч гэсэн хэлсэн шүү дээ. Нөгөө тэгээд хэлэлцээрийн тэр деталь тэрийг бол Хянан шалгах түр хорооны үндсэн хүрээнд орохгүй байхгүй юу. Тэгэхээр тэрийгээ Засгийн газар ажлын хэсгийнхээ хүрээнд ярилцаад явах ёстой. Тэгээд хурал нээлттэй явна аа. Тэгэхээр

ажлын хэсгийн явж байгаа тэр процесст нээлттэй ярих боломжтой зүйлээ л яриарай л гэж байгаа юм.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофон Ганхүү захирал.

Э.Ганхүү: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе эрдэнэс Оюу толгой компани Ганхүү. Монгол Улсын Ерөнхий сайдын 67 дугаар захирамжаар Монгол Улсын Сангийн сайд Жавхлан сайдаар ахлуулсан хүүний хэлцэлд орох ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг байгуулагдаад мөн ажлын хэсэг дэмжлэг буюу яг эрх зүйн үндэслэлийг судлах дэд ажлын хэсгийг байгуулсан. Дэд ажлын хэсгийг Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга ахлаад, миний бие дэд даргаар тэгээд бусад холбогдох мэргэжлийн багтай өнөөдрийн байдлаар нийтдээ 6 удаагийн хурлыг хийж ажиллаж байгаа. Энэ хугацаанд бид бүхэн зээлийн хүүг Эс энд Би Мүүдис зэрэг олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагаас гаргасан загварчлалын дагуу хувилбар тооцооллуудыг хийсэн байгаа. Оюу толгой компанийн санхүү тооны өгөгдөлд дүн шинжилгээ хийсэн. Олон улсын зах зээлд гарсан зээл бондын судалгааг гүйцэтгэж ажиллаж байгаа.

Хувилбар тооцоолол олон улсын зах зээлийн судалгааны дагуу хэлэлцээрийг техник тактикийг боловсруулаад мөн судалгаа, эх сурвалж, холбогдох бүх мэдээллийг албан ёсны баталгаажуулах харьцуулсан судалгаануудыг өшөө өргөтгөх ажлуудыг хийсэн. Өнөөдрийн байдлаар бид бүхэн 10 сарын 13-ны өдөр Рио Тинто буюу хувь нийлүүлэгчдийн хамаарал бүхий талуудаа хэлэлцээрийг 2025 оны 10 сарын 27-ноос 31-ний хооронд зохион байгуулъя гэсэн саналыг албан ёсны мэдэгдлээ хүргүүлсэн. Рио Тинто компаниас 10 сарын 27-оос 31-ний хоорондох хоногуудыг хүлээн зөвшөөрч байна. Мөн одоо хүүгийн буюу Онтрэ бусад энэ Оюу толгой төсөлтэй хамааралтай тулгамдаж байгаа бүх хэлэлцээр хийх асуудлыг 10 хүний бүрэлдэхүүнтэй томилогдохоор батлагдлаа.

Тэгээд 27-оос 31-ний хоорондох хугацааг хүлээн зөвшөөрч байна гэсэн хариу ирсэн байгаа. Бид бүхэн өнөөдрийн байдлаар яг Монголд яг хэдний өдөр нь буух юм, яг хэдний өдөр хаана хурлыг товлох вэ гэдэг асуудлаа өнөөдөр сая 13 цагаас өргөтгөсөн ажлын хэсгийн хуралдаан дээр яриад албан ёсны ажлын хэсгийн дарга нараасаа чиглэлээ аваад дараагийнхаа боловсруулалтынхаа шат руу орохоор бэлтгэлээ хангахаар байгаа. Мөн хүүний асуудлаар бид бүхэн бас ганцхан ажлын хэсгээр биш, хөндлөнгийн давхар зөвлөх багуудаар эрдэмтэн судлаач дээр давхар тооцоолол судалгааг хийж өөрсдийнхөө гаргасан тооцооллыг баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлье ээ гэсэн тийм ажлуудыг зохион байгуулж байгаа. Онтрэгийн хувьд гэх юм бол мөн Ерөнхий сайдын 73 дугаар захирамжаар, Ерөнхий сайдын 68 дугаар захирамжаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Энэ ажлын хэсэг маань дотроо 3 дэд ажлын хэсэг байгуулсан. Энэ 3 дэд ажлын хэсэг маань өнөөдрийн явц процедурын дагуу Онтрэгийн тусгай зөвшөөрлүүд нь анхны эх сурвалж нь буюу Монгол Улсын Засгийн газартай ямар хамааралтай, ямар хувь хэмжээг тогтоосон байгаа, эрх зүйн үндэслэл нь юу байгаа вэ гэсэн үндсэн гол асуудлыг бол дэд ажлын хэсгүүд хийж байгаа. Дэд ажлын хэсэг гэх юм бол Уул уурхай, байгаль орчны асуудал хариуцсан ажлын хэсэг, гэрээ эрх зүйн ажлын хэсэг, эдийн засаг, санхүү, татварын ажлын хэсэг гэсэн үндсэн 3 дэд ажлын хэсэг ажиллаж байгаа.

Ажлын хэсгүүд бол холбогдох яамдын буюу Хууль зүйн яамны ТНБД, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД, гэрээ эрх зүй эрх зүйн ажлын хэсгийг Хууль

зүйн яам гэсэн төрийн нарийнууд ахалсан ажлын хэсгүүд байгуулсан байгаа. Уул уурхай байгаль орчны чиглэлийн ажлын хэсэг гэх юм бол Оюу толгой ХК-ийн ТЭЗҮ-ийн тодотгол буюу санал, дүгнэлт өгсөн шинжээчдийн багтай уулзалт хийгээд дүгнэлт гаргах нь зүйтэй юм байна аа гэсэн нэгдсэн байр сууринд хүрсэн байгаа. Энэ ажлууд хийгдэж байгаа. Гэрээ, эрх зүйн ажлын хэсэг бол Онтрэ компани Монгол Улсын ямар хууль тогтоомжийг зөрчсөн талаарх судлах мөн яг Онтрэ компанийн яг бодит өнөөдөр Монгол лиценз эзэмшигч болсноос хойш Монгол улсад яг уул уурхайн буюу ашигт малтмалын хуулийн дагуу ямар процессоор яаж энэ хууль дээр ажиллаж байгаа гэсэн үндсэн гол асуудлуудыг судлаад ерөнхийдөө суурь судалгаа, суурь гэрээ, эрх зүйн эх сурвалжуудыг яг бодит удирдамжийн дагуу зохион байгуулах ажлууд хийгдээд явж байгаа. Баярлалаа.

Танилцуулгатай холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Зулпхар гишүүнээр тасалъя. Зулпхар гишүүний микрофоныг өгье.

С.Зулпхар: Түрүүн дарга гишүүд ажлын хэсгийнхний энэ өдрийн амгаланг айлтгая. Бидний хувьд бол их тийм сайшаах учиртай үр дүн гарч байна гэж ойлгож байна. Учир юу вэ гэхээр зэрэг энэ төслийн хүрээнд оролцогч талууд хэлэлцээрийн ширээн дээр тал талаасаа суухаар болж байгаа юм байна. Тэрнээс гадна тодорхой асуудлаар бол манай талын ажлын хэсэг маш шуурхай ажиллаад тэрнээс гадна их тийм үр дүнтэй ажиллаад хэлэлцээрт суух хэлэлцэх асуудлынхаа хувилбаруудыг гаргасан нь өөрөө их тийм цаашаа урагштай байна.

Нөгөөтэйгүүр бид асуудалд нэг тийм мэргэжлийн болон экспертийн түвшинд хандаж байгаа нь их сайн юм байгаа юм. Аль болох л ямар нэгэн улс төрийн их өнцгөөс биш асуудал мэргэжлийн хандах тусмаа нөгөө талтайгаа хэлэлцээр хийхэд амар байдаг. Хэт их улс төрийн нөхцөл байдал үүсгэх юм бол нөгөө тал ч гэсэн тэрийг янз янзаар жишээ нь ойлгох, янз янзаар тэрийг ашиглах байдал үүсдэг учраас би ажлын хэсгийнхэнд талархаж байна. Гэхдээ ажлын хэсгийнхнийг бас нэг ийм байдлаар эрчимтэй ажиллахад Улсын Их Хурал дээр байгуулагдсан Хянан шалгах түр хороо их чухал үүрэгтэй байсан гэдэгт эргэлзэхгүй байна.

Батнайрамдал гишүүн бол манай бусад гишүүдийн энэ хүчин чармайлт угаасаа үүрэг нь шүү дээ. Энэ үүднээс бид энэ асуудалд үр дүн гарч байгаад бие биедээ тодорхой түвшинд хэлж байх ёстой гэж бодож байгаа юм. Та бүхэн хэлэлцээрт угаасаа орох юм байна. Хэлэлцээрт орох үед бол мэдээж хэрэг гол зүйл бол бид байнга хэлж байгаа мессеж байгаа юм. Бид хөрөнгө оруулагчдын эрх ашгийг бол өнөөдрийг хүртэл хамгаалсаар, хангасаар ирсэн шүү гэдгийг бол маш тодорхой илэрхийлэх ёстой. Цаашдаа ч гэсэн хөрөнгө оруулагчдын бид эрх ашгийг бол Монгол Улс хамгаална. Бас итгэлийг нь энд төрүүлэх бүхий л эрх зүйн орчныг бид хангалттай үгүйсгэж хичээж байгаа гэдгийг хэлэх ёстой шүү. Тэгэхгүй бол заримдаа хөрөнгө оруулагчдыг үргээх гээд ажиллаад байгаа юм шиг ийм буруу ойлголтыг зориуд төрүүлэх хандлага байж магадгүй. Энийг бол манай Түр хороон дарга байнга илэрхийлж байгаа шүү дээ. Бид хөрөнгө оруулагчидтайгаа бол ширээний ард эрх тэгш харилцан ашигтай байх энэ зарчим дээр суурилж байгаа шүү гэдэг талаас нь хэлж байгаа. Энийг та бүхэн хэлээрэй гэдгийг хэлж байгаа. Би зориуд уншиж тэмдэглэж байна.

Нөгөөтэйгүүр нэг зүйл бий. Монгол Улсад энэ чинь бүртгэлтэй компани шүү дээ. Тэгэхээр Монгол Улсын хууль бүрэн хэрэгжих ёстой шүү гэдгийг нөгөө талд хэлмээр байна. Монгол Улсын хуулиас гадуур янз янзын байдлаар асуудалд

хандаад эхлэх юм бол энэ өөрөө эрх тэгш биш байдлыг үүсгэнэ. Эцсийн дүндээ энэ өөрөө ахиад улс төр рүү хөтөлчихдөг. Бид улс төр рүү асуудлыг хөтлөх ерөөсөө сонирхолгүй байгаа шүү дээ. Асуудал бол 3.5 сая Монголчуудын эрх ашгийг хангасан энэ том төсөл дээр бид өөрийнхөө эрхийг л бүрэн хангуулахад чиглэсэн ийм л хэлэлцээрийг хүсэж байгаа шүү гэдгийг хэлье ээ.

Ингээд та бүхний ажилд амжилт хүсье. Хэлэлцээр амжилттай болох болтугай. Баярлалаа.

О.Батнайрамдал: Баярлалаа. Болормаа гишүүний микрофон өгье.

Э.Болормаа: Ингээд танилцуулга тавьсан ажлын хэсгийнхэндээ баярлалаа. Энэ Түр хорооны нэлээн их шахалтаар олон нийтэд энэ мэдээллийг хүргэсний ачаар ажлууд арай хурдацтай явж байгаад баярлаж байна. Тэр дундаа зөвхөн Онтрэ зээлийн хүү гэхгүйгээр эргээд Улсын Их Хурлын 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор бас энэ ажлуудыг эргэн гаргаж ирж байгаад баяртай байна аа. Бүүр онцолж хэлэх юм бол энэ 3 дэд ажлын хэсэг буюу Оюу толгой компанийн менежментийн үйлчилгээний гэрээг шинэчлэх, Оюу толгой компанийн засаглалыг сайжруулах бид жишээлбэл хараат бус гишүүдтэй байх ТУЗ-ийн дэргэдэх энэ хороодын үйл ажиллагааг сайжруулах гэх мэтчилэн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт зардалд хөндлөнгийн аудит хийлгэх. Монгол Улс энэ үүсээд байгаа энэ өр дээрээ хөндлөнгийн аудит хийлгэх, нэмэлт зээлийн санхүүжилт, эрчим хүч, ус ашиглалт, байгаль орчин, нийгмийн асуудлыг сайжруулах гэсэн энэ 3 зүйл дээр та бүхэн маань Онтрэ болон зээлийн хүүгийн хажуугаар бас тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал хийгдэж байгаад баяртай байна аа.

Би нэг зүйлийг Дамдинням сайдаас асууя.

Монгол Улсын талаас Оюу толгой компанийн ТУЗ-д 3 гишүүн байдаг. Монгол Улсын талаас. Нэг гишүүнийг нь өөрт нь мэдэгдэлгүйгээр Засгийн газрын хуралдаанаар чөлөөлсөн байна аа. Энэ гишүүн бол 2.3 тэрбум долларын өрийг тэглүүлэх ажил, ер нь Монгол Улсын эрх ашгийн төлөө маш хүчтэй дуу хоолой байсан. Би хэд хэдэн эх сурвалжуудаас Рио Тинто компани энэ гишүүнийг л холдуулаад өгвөл бидэнд их хэрэгтэй байна аа гэдэг байр суурийг илэрхийлж байсан гэж ойлгож байгаа юм. Яагаад энэ гишүүнийг чөлөөлөх болов оо? Энэ дээр албан ёсны тайлбар авъя аа.

О.Батнайрамдал: Дамдинням гишүүний микрофон. Болормаа гишүүний асуултад хариулъя.

Г.Дамдинням: Яах вэ Түр хорооны гишүүддээ талархал илэрхийлье. Ер нь бол бид нар Монголын ард түмний төлөөлөл болж Их Хурал болон Засгийн газрын хүрээнд хамтын нягт ажиллагаатайгаар энэ ажлыг урагшлуулж байгаа. Дан ганц Засгийн газар асуудал яриад явахад бол хэлэлцээр дээр нөмөр нөөлөг хэрэгтэй байдаг. Энэ утгаараа бол Оюу толгойн бүлэг ордын ашиглалтын талаар Хянан шалгах түр хороо байгуулж ажиллаж байгаа эрхэм гишүүдийн та бүгдийн маань дэм тус их байгаа. Бид яг нэг улс нэг баг хамт олноороо ингээд шахаж ажлыг явуулж байгаа. Тийм ч учраас бид нар энэ хүмүүсийг ширээнд суулгаж багцаар нь асуудлуудаа шийдье. Тэр бүү хэл нэмэлт үндсэндээ бидний дунд байгаа том хэмжээний асуудлууд түрүүн Болормаа гишүүн дурдаж хэллээ. Энэ асуудлуудаа нэгмөсөн яриад явъя аа. Тэгэхдээ хэлэлцээрийнхээ дарааллуудад ингээд оруулаад

явъяаа гэдэг ийм чиглэлтэй ажиллаж байна. Тэгээд тэр ТУЗ-ийн гишүүнтэй холбоотой асуудлыг бол би Хэрэг эрхлэх газар нөгөө нэг Эрдэнэс Монгол гэдэг компанийн төрийн төлөөллийг бүрэн хэрэгжүүлдэг юм.

Манай яам бол энэ дээр оролцоо байдаггүй. Тэгээд би бол ер нь Хэрэг эрхлэх газраас тодруулах ёстой байх гэж бодож байна. Би ч гэсэн олны мэдээллээс л сонссон. Одоо бол би яг цэвэр энэ нөгөө нэг хэлэлцээр дээр ажлын хэсэг ахлаад ингээд ажиллаж байгаа. ТУЗ-ийн гишүүнд бүр үеийн үед ажиллаж байсан хүмүүстэйгээ бүгдэнтэй нь уулзаж ажиллаж байгаа. Энд таны нэр дурдсан гишүүнтэй ч гэсэн би энэ уулзаж саналыг нь сонссон. Ийм байвал зүгээр байдаг ийм асуудлууд байдаг гээд тэр юуны ч асуудлууд байгаа юм. Нөгөө хөндлөнгийн экспертүүд байдаг юм. Тэгээд хөндлөнгийн экспертүүд үе үед ажиллаж байсан хүмүүсийг сонсож байгаа. Мөн бид нар энэ Улсын Их Хурал дээр үеийн үед байгуулагдаж байсан ажлын хэсгүүд байдаг юм байна лээ. Тэдгээрийн протокол тэдэнд ирж байсан бичиг баримтуудыг татаж авч ажиллаад ингээд нэгтгээд явж байгаа.

Тухайлсан хүнтэй холбоотой асуудлыг бол Хэрэг эрхлэх газраас тодруулаад хэлэхэд болох байх. Би тэгээд яг сайн мэдэхгүй юм.

О.Батнайрамдал: Болормаа гишүүний микрофон нэмэлт тодруулга.

Э.Болормаа: Би энийг яагаад тодруулж асууж байна вэ гэхлээр энэ Засгийн газрын Хэрэг эрхлэхийн газар түүний сайд энэ улс төржилттэйгөө холбоотойгоор ийм шийдвэр гаргасан байх вий. Энэ хүнийг сонгон шалгаруулалтаар энэ чинь зүгээр томилогдсон биш. Сонгон шалгаруулалтаар бид гадаадад ажиллаж байхад нь гадаадын том банкнуудад ажиллаж байхад нь урилгаар авчирсан өнөөдөр энд байгаа мөн ТУЗ-ийн гишүүн Мэнд ээ мэтчилэн энэ залуучуудыг бол сонгон шалгаруулалтаар урьж авчирч байдаг. Тэгээд бид бүгд энэ хүмүүсээ улс төрийн байр сууриас нь болж ийм улс төржсөн шийдвэр гаргаснаас болж наадах чинь эргээд Монгол Улсад халтай шүү гэдэг юмыг би сануулах гээд байгаа юм. Улс төрийн ажлыг төрийн ажлаасаа салгах ёстой шүү. Хэрэг эрхлэхийн газар ийм байдлаар хандах юм бол наад хэлэлцээр чинь амжилтгүй болно шүү.

О.Батнайрамдал: Дамдинням сайд нэмэлт тодруулга. Дамдинням сайдын микрофон өгье.

Г.Дамдинням: Тийм Болормаа гишүүн таны саналыг сонслоо ойлголоо. Тэгээд яах вэ Монголын нийт 3.5 сая ард иргэдийг төлөөлж Оюу толгой компанид 3 төлөөлөл суудаг, ТУЗ-д нь. Бид бол энэ асуудлыг шүүмжлэлтэй ханддаг. Энэ удаад бид нар ТУЗ-ийн гишүүд, харьяал, харьяалах компаниуд, төрийн бүтцийн бүх байгууллагууд нэгдэж 1 ажлын хэсэг болж орж хэлэлцээрт орж байгаагаараа их онцлог байгаа. Тэгэхгүй бол ингээд тус тусдаа салж яваад ямар ч үр дүн хүрэхгүй их удаан хугацааг өнгөрөөсөн байна лээ. ТУЗ-тэй холбоотой асуудал дээр ТУЗ-ийн гишүүд маань ямар нэг тайлан тавьдаггүй, хаа нэг газар харьяалагддаггүй? ажлын даалгавар авдаггүй ийм асуудлууд байсан. Засаглалын энэ хариуцлагагүй нөхцөл байдлыг бид нар энэ ажлынхаа хүрээнд цэгцлэх асуудлыг хийгээд явж байгаа. Эрдэнэс Монгол компанийн харьяа Эрдэнэс Оюу толгой компани дээр гэрээ хийдэг, тэрэндээ тайлангаа тавьдаг, нэгдсэн чиглэлээ аваад явдаг зохицуулалтыг хийнэ гэсэн өөрчлөлтүүдийг хийх гэж байгаа шүү дээ.

О.Батнайрамдал: Хариулт хангалтгүй хариулт хангалтгүй гэж үзсэн учраас Болормаа гишүүн нэмэлт тодруулга.

Э.Болормаа: Саяын миний асуулт болон санал нэг тийм тодорхой бус байх шиг байна. Засгийн газрын хурлаар ТУЗ-ийн гишүүн Баясгаланг яагаад чөлөөлсөн гэдэг протоколыг би авах хүсэлтэй байна аа Батнайрамдал дарга. Яагаад гэвэл энэ шалтгаан нь тодорхойгүй байвал ажил хэрэгч бус, мэргэжлийн бус байвал энэ өөрөө улс төржсөн шийдвэр гаргасан байна аа л гэсэн үг байхгүй юу.

Тэгэхээр өөрсдийн эрх ашиг улс төрийн шийдвэрээс болж ийм Монгол Улсад хохиролтой шийдвэр гаргаад байх юм бол наад хэлэлцээр чинь яаж явах вэ гэдэг ийм зарчмын асуудал хөндөж шаардлага тавьж байгаа гэж та бүхэн ойлгоорой. Та бүхэн бүгдээрээ хамтдаа Монголын эрх ашгийн төлөө ажиллана аа гэдэгт би итгэлтэй байна л даа. Тэгэхдээ энд процесс буюу энэ аль ч ТУЗ-ийн гишүүнд дараа хамааралтай юм байхгүй юу. Яг ямар шалтгаанаар нь тодорхойгүйгээр хүнийг шууд улс төржсөн байдлаар халсан уу, үгүй юу гэдгийг бид эргээд харах ёстой шүү гэдэг энэ асуудлыг хөндөж байгаа юм.

О.Батнайрамдал: Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Д.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэр нөгөө манай Эрдэнэс Оюу толгой компанийн засаглалыг сайжруулах 20 сая долларын маань нууцын асуудал эцэслэгдэн шийдвэрлэгдсэн юм уу үгүй юу? Дал гаран тэрбум төгрөгөөр менежментээ сайжруулах гэж байгаа гэдэг ийм ойлголт авсан. Тэгээд энийг 1 дүгээрт би асуумаар байна.

Хоёрдугаарт түрүүн хэлчихлээ. Энэ дэд ажлын хэсгүүд байгуулсан уул уурхай, байгаль орчин, гэрээ эрх зүй, эдийн засаг, санхүү, татвар гээд 3 дэд ажлын хэсэг байгуулагдсан гээд сая мэдээлэл хийж байх шиг байна. Бид нар энэ ажлын хэсгийн нэгдсэн стратегийг тодорхойлох эрсдэл болон олон нийтийн оролцоог удирдахтай холбоотой асуудлуудаа яах юм? Ерөөсөө энэ стратеги чинь өөрөө нэгдсэн стратегитай явж байгаа юм уу үгүй юу гэдэг чинь маш эргэлзээтэй түвшинд байгаад байна шүү дээ. 1, 2 тал манай танай гээд хуваагдчихсан. Стратеги нь яг хаана байгаа юм? Тэгээд энд тэнд гэнэт нууцын материал гарч ирдэг. Гэнэт нөгөө тал нь үл ойлгогдох нөхцөл байдлыг үүсгэдэг.

Тэгэхээр энэ дээр энэ үндсэн чиглэл дээрээ та хэд маань энэ эдийн засаг, хууль, улс төр, байгаль орчны эрсдэлийн үнэлгээг яаж хийх гэж байгаа юм энэ ажлын хэсгүүд дээр энийг яаж тооцож байгаа вэ гэдгийг би 1 дүгээрт асуух гэж байгаа юм. Тэгээд ер нь зүгээр ил тод биш байдалтай холбоотой, мэдээллийг хязгаарласантай холбоотой, олон нийттэй харилцах харилцааг хязгаарласантай холбоотойгоор л олон асуудлууд үүсэж байгаа шүү дээ.

Өнөөдөр Оюу толгой компани нэг дуудаад 3 удаа ирсэнгүй. Тэгээд энэ өөрөө ийм нөгөө нэг талдаа эрсдэлтэй гэдэг нөхцөл байдлыг Оюу толгой компани илэрхийлээд байгаа юм шиг, нөгөө талдаа бид нараас юу нуугаад байгаа юм бэ гэдэг ийм хардлага сэрдлэгийг нөгөө талдаа төрүүлээд байгаа байхгүй юу. Тэгээд бид нар ер нь зүгээр энэ эрсдэлийн үнэлгээгээ цаашдаа яаж явах юм бэ? Энэ 3 дэд ажлын хэсэг дээрээ эрсдэлийн үнэлгээгээ тус тусад нь хийж явах гэж байгаа юм уу? Тэгээд төслийн хэрэгжилтийн үе шат, стратегийн хяналттай холбоотой асуудлуудаа

хэдүүлээ яаж шийдвэрлэх юм. Энийгээ дэд ажлынхаа хэсгийн хүрээнд шийдвэрлээд явчих юм уу үгүй юу гэдгийг тодруулах гэж байгаа юм. Баярлалаа.

О.Батнайрамдал: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Дамдинням сайдын микрофон.

Г.Дамдинням: Манай Бат-Эрдэнэ гишүүн яг өөрөө өмнө нь ийм хэлэлцээрт орж байсан хүн яг л гол асуудлуудын нэгийг барьж авч асууж байна. Тийм бид нар бол нэгдсэн стратегитай ажиллана. Энэ бүх ажлын хэсгүүд түрүүн би хэлсэн. 103-ын хүрээнд 103 дугаар тогтоолын хийгдэж өгөх энэ 67, 68, 73 гэсэн энэ 3 тогтоолын хэрэгжилтийг ажлын хэсгүүд захирамжаар байгуулагдсан 3 ажлын хэсэг Улсын Их Хурлын 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд нэгдсэн ажлын төлөвлөгөө, хэрхэн хэлэлцээр хийх удирдамж, нэгдсэн хэлэлцээрт орох хүмүүсийн бүрэлдэхүүн, тэгээд тэрийгээ дагаад явах шинжээчдийн баг зөвлөх үйлчилгээний баг энэ тэр бүгдээрээ нэгдсэн зохион байгуулалттайгаар ажиллах ийм л стратегитай байгаа, нэг.

Хоёрдугаар асуудал бол энэ яригдаж байгаа бүх асуудлууд бүгдээрээ уялдаа холбоотой. Нэг нэгнээсээ хамааралтай. Магадгүй ний нуугүй энүүхэндээ хэлэхэд нөгөө тал маань нэгийг нь түрүүлж ярих сонирхолтой байдаг бол бид нар өөр тэрийг нь дараа нь ярих ч гэдэг юм уу ийм юмнууд байгаа учраас бид нар стратеги тактикаа бол боловсруулсан. Түрүүн Ганхүү захирлын танилцуулсан танилцуулга дээр харагдсан байх. Зарим нь ч хамаагүй харуулахааргүй юмнууд байгаа. Эрх зүйн хувьд ямар эрсдэл байгаа вэ? Эрх зүйн үр дагавраасаа гарах санхүүгийн эрсдэл нь ямар байгаа вэ? Энэ үед бид нар ямар арга хэмжээ авч хариу барих вэ гэдэг тооцооллуудаа бол бид нар хийчихсэн байгаа. Өөрсдийн модулийг нь гаргачихсан байгаа. Тэгээд энэ дээрээ л ажиллана. Тэгээд Засгийн газраас үндсэндээ тогтоолоор Засгийн газрын тогтоол байх уу эсвэл Ерөнхий сайдын захирамжаар байх уу? Энэ нөгөө нэгдсэн нөгөө нэг хэлэлцээрт орох удирдамжаа батлуулж авах юм. Өнөө маргаашгүй. Тэгээд энэ 10 сарын сүүлээр бид нар хэлэлцээртээ орох гээд байгаа юм. Товчхондоо нэг ийм л юм байгаад байгаа шүү дээ.

О.Батнайрамдал: Бат-Эрдэнэ гишүүнд нэмэлт тодруулга.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тодруулах юм сайдаас тодруулах юм алга. Зүгээр Батнайрамдал даргад нэг санал байна. Дамдинням сайд түрүүн хэлсэн хэрвээ энэ Оюу толгойн бүлэг ордын ашиглалтын талаар Хянан шалгах түр хороо нарийвчилсан мэдээлэл сонсъё оо гэвэл хаалттай хуралдаан хийгээд тэн дээрээ бид нар тодорхой мэдээллүүдээ өгөх боломжтой гээд хэлсэн.

Өнгөрсөн цаг хугацаанд бол бид нар 2009 он, 2011 он, 2018, 2025 онтой холбоотой энэ асуудлуудыг бид нар хөндөж ирсэн шүү дээ. Бид нар зээлийн хувь нийлүүлсэн зээлийн гэрээ хэлэлцээр, тодотгол, нөгөө хэчнээн хэмжээний мөнгө алдах гээд байна гэдэг ч юм уу. Яах вэ хэдийгээр манай нөгөө ажлын цар хүрээнд орохгүй байгаа гэдэг асуудлууд нэг талдаа хөндөгдөөд байгаа боловч бид нар цаашдаа авах арга хэмжээтэй холбоотой асуудлыг олон нийтэд мэдээлээд яваад байгаа учраас энэ энэ дээр нэг удаа зүгээр сонсчих боломж байхгүй юу гэдэг санал байна.

О.Батнайрамдал: Дамдинням сайд нэмэлт тайлбар өгчих. Дамдин сайдын микрофон. Яах вэ наадах чинь Дамдинням сайдын л хариулт байна л даа.

Г.Дамдинням: Тийм яах вэ болно. Гэхдээ хэлэлцээрт орох гээд байгаа учраас энэ саяын энэ бид нарын тооцооллууд, тэгээд алийгаа түрүүлж түлхэх юм алиагаа татах юм гэдэг асуудлаа бол Засгийн газрын ажлын хэсгийнхээ хүрээнд байлгаж байвал яасан юм бэ л гэсэн байр суурьтай байна. Мэдээж Улсын Их Хурлын гишүүний онцгой бүрэн эрх бүх мэдээллийг авах эрхтэй учраас нөгөө хэлэлцээрийн тактикаа нийтэд нөгөө тал маань сонсоод байгаа учраас л бид нар одоо бас хаалттай хэлэлцчихвэл яасан юм бэ гэж байгаа. Ажил хэргийн шугамаар танилцчихаж болно Бат Бат-Эрдэнэ гишүүн ээ тиймээ.

Нээлттэй тэгээд нээлттэй яах юмнуудыг танд ажил хэргийн шугамаар танилцуулчихаж болно шүү дээ тийм.

О.Батнайрамдал: Гишүүд асуулт асууж, үг хэллээ.

Эцэст нь бас Хянан шалгах түр хорооны даргын хувьд нэг дараагийн 7 хоног гээд Лондонгоос ирж байгаа Рио Тинтогийн багтаа хэлэлцээрт орох гэж байгаа гэж ойлголоо. Энэ удаагийн хэлэлцээр бол олон нийтийн маш том хүлээлт дээр явах гэж байна. Хэлэлцээрт орж байгаа тэр баялаг нь өөрөө бас яг төрийн нийтийн өмч буюу ард түмний өмч л дөө. Тэгэхээр ард түмэн энэ дээр цавчилгүй харж байх болов уу гэж бодож байна. Хянан шалгах түр хороо ч гэсэн харна.

Хамгийн гол нь түрүүн Зулпхар гишүүн ч хэллээ л дээ. Харилцан ашигтай байх тиймээ яг бизнесийн тэр зарчмаа л бариач ээ гэж байгаа юм. Монгол Улсын газар нутаг дээр Монгол Улсын баялгийн хэлэлцээр явж байгаа учраас Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжийнхоо дагуу яс л явах ёстой. Бид нар бол нэмэлт зүйл асуугаагүй шүү дээ. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын хууль тогтоомждоо нийцсэн арилжааны зарчмаар тиймээ харилцан ашигтай хамтран ажиллах энэ хүрээндээ л хэлэлцээр яваасай. Улсын жишигтэйгээ ойртоосой. Урьд өмнөх алдаануудаасаа суралцаад алдаа хийж болно оо. Харин алдааг мэдсээр байж давтаж болохгүй. Бид нарт тийм эрх байхгүй.

Ер нь ямар ч улсад улс төрийн шуургатай цастай үе байдаг аа. Гэхдээ ийм ямар ч улс төрийн нөхцөлд бол Монгол Улсын парламент Монгол Улсын Засгийн газар Оюу толгойн хэлэлцээр дээр баттай хамтдаа нэг байр суурь дээрээ байна гэдгийг дахиад илэрхийлмээр байна. Яагаад гэвэл бид нар бүгдээрээ парламент ч ялгаагүй Монгол Улсын Засгийн газар ч ялгаагүй Монголын 3.5 сая иргэн тэр битгий хэл ирээдүйд төрөх Монгол хүүхдэд хамааралтай зүйлийг Монголын төрийн нийтийн өмчийн хэлэлцээр дээр ярьж байгаа учраас энэ дээр хамтдаа зогсоно оо. Ямар ч зүйл тохиолдож болно энэ дээр бид нар хамтдаа байна.

Тийм учраас энэ хэлэлцээрийг бид бүхэн амжилттай хийх ёстой. Урьд өмнөх алдаанаасаа суралцаж илүү сайжруулсан, илүү ашигтай ийм л хэлэлцээр явах ёстой, цоо шинэ зүйл ерөөсөө биш шүү. 2009 оны Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан. Яг түүнтэй адилхан Онтрэ дээр бол адилхан хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдана гэсэн үг. Зээлийн хүү бас тиймээ олон улсын жишигтэй нийцүүлээд л буурах ёстой. Тэрнээс биш дэлхий дээр байхгүй юм ерөөсөө асуугаагүй шүү. Олон улсын жишигтэйгээ л нийцүүлээч ээ л гэж байгаа. Харилцан ашигтай байх тэр боломжийг бүрдүүлээч ээ л гэж байгаа. Тэгээд нэгэнтээ гишүүд ч бас ярилаа. Оюу толгойн яг Хянан шалгах түр хороо ажиллаж эхлэхэд бол 30 гаруй мянган хуудас нотлох баримт бүхий бичгүүд бол Оюу толгой компаниас бүгд нэг бүрчлэн

байгууллагын нууц гэсэн тэмдэгтэйгээр ирсэн. Энэ бас Оюу толгойгоор хязгаарлагдахгүй юм аа Дамдинням сайд аа. Энэ бол Монгол Улс дээр Монгол Улсын талд Монгол Улсын Засгийн газар дээр тэр дундаа Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Сангийн яам, ЗГХЭГ-ын гарсан, ирсэн хоорондын харилцаа мөн гарсан ажлын тайлангууд нууцын тамгатай байна аа. Тэр битгий хэл зарим нь маш нууцын тамгатай байгаа шүү. Тэгэхээр энийг ил болгох бүрэн эрх нь Монгол Улсын Засгийн газарт байгаа.

Монгол Улсын Засгийн газар ч гэсэн ер нь нүүрсэн дээр ч гэсэн тиймээ бүх зүйлээ ил тод болгоно оо. Ил тод төрийн нууц гэдэг тамгын ард маш олон зүйл явсан байна. Энийг бүгдийг нь ил тод болгоно оо гэж зарласан.

Тэгэхээр энэ зөвхөн нүүрсээр хязгаарламааргүй байна. Оюу толгойн асуудал дээр ч гэсэн хэдэн тэрбумын асуудал ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр төр өөрөө нууц дарсан шаардлагагүй тэр бичиг баримтуудыг зарим нь бүүр хугацаа нь дууссан байгаа шүү. Тэр 2007 онд дарсан тэд нар чинь хугацаа нь дуусчихсан. Гэтэл нууцын тамгатай одоо хүртэл байсаар л байна. Энэ өөрөө бас ард түмний мэдэх эрхийг ноцтой зөрчих ийм асуудал үүсэх гээд байгаа юм.

Тийм учраас өнөөдөр Монгол Улсын Засгийн газар руу албан ёсоор Хянан шалгах түр хорооноос энэ яамдуудын Засгийн газрын хоорондын тэр ажлын тайлан болон захидал харилцаа энэ дээр нууц дарсан энэ бүгдийг нь ил болгооч ээ. Засгийн газарт бүрэн эрх нь байна аа. Энэ дээр яаралтай хууль журмынхаа дагуу бүгдийг нь ил болгож өгөөч ээ гэсэн хүсэлтийг албан ёсоор явуулсан байгаа.

Тэгэхээр энэ дээр бүх тэр тухайн тэр нууцад авсан мэдээллүүдийг бүгдийг нь хууль журмынхаа дагуу ил болгож өгөөч ээ гэж Хянан шалгах түр хорооны зүгээс хүсэж байгаа юм. Энэ бол буцаад Хянан шалгах түр хорооноос 11, 12 сард явуулах олон нийтийн сонсголд маш том хувь нэмэр оруулах учраас үүнээс шууд хамаарах учраас Оюу толгой шиг ингээд нууц гэдэг үгийн ард ард түмний мэдэх эрх битгий зөрчигдөөсэй л гэж хүсэж байгаа юм. Мөн Оюу толгой өнөөдөр танилцуулгаа ирж хийсэнгүй. Энэ бол Оюу толгой компанид Хянан шалгах түр хороонд мэдээллээ ирж өөрсдийн өнцгөөс тайлбарлах танилцуулгаа хийх боломжтой.

Тэгэхээр тэр боломжоо ашиглах ёстой парламентад хүндэтгэлтэй хандах ёстой. Энэ нь цаагуураа ч гэсэн Зөрчлийн тухай хуультай хууль зөрчиж байгаа хэрэг шүү дээ. Тэгэхээр ингэж битгий хандаач ээ. Өөрийнхөө энэ мэдэх эрхийн хүрээнд энэ боломжоо парламент дээр ирж хэрэгжүүлэх үүрэгтэй. Тэгэхээр энэ үүргээ заавал биелүүлэх ёстой. Зарим гишүүд ч гэсэн хэлж байна шүү дээ. Бүүр болохгүй бол бид нар өөрсдөө яваад очъё. Оюу толгой компани дээр бид нар Хянан шалгах түр хорооныхоо хүрээнд ч гэсэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх ч байна. Өөрсдөө очоод компани дээр нь очоод танилцъя аа. Үнэхээр аюулгүй байдал нь парламентын ордонд хангагдахгүй гэж үзэж байгаа бол бид нар өөрсдөө очиход бэлэн байна аа.

Харин дахиад л нууц гэдэг энэ том асуудал байхад өөрсдөө нууцтай тэгээд хуралдахыг бид нар хүсэхгүй байна. Энэ бол Хянан шалгах түр хорооны ч гэсэн зарчим байгаа.

Тийм учраас энийгээ бүгдээрээ олон нийтэд мэдэх эрхээр нь хангах хүрээндээ болохгүй бол дараагийн хурлаас Хянан шалгах түр хороо шийдвэрээ гаргаад яваад очъё оо л гэж байгаа.

Гэхдээ дараагийн 7 хоногт хэрвээ хэлэлцээр явж байхад бол бас хажуугаар нь тэгж бид нар явах уу гээд тэрийг цаг хугацааны асуудал. Ер нь цаашдаа ч гэсэн Хянан шалгах түр хорооны гишүүд зарим одоо ажлын хэсэгтэйгээ хамт сайт дээр нь очиж бид нарын ярьж байгаа зүйл тэр Онтрэгийн талбайгаа тэр ил далд уурхайгаар очиж үзье гэж байгаа юм. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Тэрийг шийдэж болно оо болно. Тэгээд хэлэлцээрт орж байгаа Засгийн газарт ямар ч байсан амжилт хүсье. Парламент Засгийн газар 1-д байна. Гэхдээ та бүхэн энэ удаа маш том ард түмний итгэл дор ард түмний хүлээлт дор хэлэлцээрт хийж байгаа шүү. Үндсэн хуулиа биелүүлээрэй. Хууль тогтоомжоо биелүүлээрэй. Тэгээд Монгол Улсад хамгийн үр өгөөжтэй тэр хувилбараа сонгож хийх ёстой шүү. Хянан шалгах түр хороо бас энэ дээр анхааралтай бид нар ажиглаж явах болно оо.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Тэгээд хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа. Тэгээд өнөөдрийн хэлэлцэх асуудал өнөөдөр дууссан тул өнөөдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье.

16.29 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА